

2018 оны 01 сарын 31 өдөр

А/30

УТГААСАН

Журам батлах тухай

"Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, "Зэвсэгт хүчний тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.14, "Биеийн тамир, спортын тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 01 дүгээр зарлигаар батлагдсан "Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын дүрэм"-ийн 2 дугаар зүйлийн 2.1.5.6, 3 дугаар зүйлийн 3.1.7, 3.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зэвсэгт хүчний цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч нарт олгох "Онц сурлагатан", "Онц буудагч", "Тамирчин дайчин" тэмдэг, үнэмлэхийн загварыг нэгдүгээр, тэмдэг олгох журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тэмдэг олгох журмыг 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
3. "Онц сурлагатан", "Онц буудагч", "Тамирчин дайчин" тэмдэг олгох журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга /хошууч генерал Ж.Бадамбазар/-д хариуцуулсугай.

ДАРГА
ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ



Д.ДАВАА

Tushaal-2018

09000100

“ОНЦ СУРЛАГАТАН”, “ОНЦ БУУДАГЧ”, ТАМИРЧИН ДАЙЧИН”
ТЭМДЭГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Зэвсэгт хүчний цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч нарт “Онц сурлагатан”, “Онц буудагч”, “Тамирчин дайчин” тэмдэг олгохтой холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч нарт эх орноо батлан хамгаалахад шаардлагатай цэргийн мэргэжил эзэмшүүлж, тэдний мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, урамшуулахад “Онц сурлагатан”, “Онц буудагч”, “Тамирчин дайчин” тэмдэгийн зорилго оршино.

1.3. “Онц сурлагатан”, “Онц буудагч”, “Тамирчин дайчин” тэмдэг нь Монгол Улсын иргэнийг цэргийн жинхэнэ алба хаах хугацаандаа эзэмшсэн цэргийн мэргэжлийн бэлтгэл, ур чадварын илэрхийлэл болно.

1.4. Тэмдэг, түүнийг олгохтой холбоотой харилцаа нь “Монгол Улсын Батлан хамгаалах тухай”, “Зэвсэгт хүчний тухай”, “Биеийн тамир, спортын тухай” хууль болон бусад эрх зүйн баримт бичигт нийцсэн байна.

1.5. Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбар нь цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагчийг “Онц сурлагатан”, “Онц буудагч”, “Тамирчин дайчин” тэмдэгтний болзолыг хангахад нь дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

1.6. “Онц сурлагатан”, “Онц буудагч”, “Тамирчин дайчин” тэмдэгийн загвар, олгох журмыг ЗХЖШ-ын даргын тушаалаар тогтоох ба түүнийг олгох, бүртгэл, тооцоог хөтлөх асуудлыг ЗХЖШ-ын Сургалт хариуцсан нэгж зохион байгуулна.

Хоёр. “Онц сурлагатан”, “Онц буудагч”, “Тамирчин дайчин”
тэмдэгтэнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт

2.1. “Онц сурлагатан”, “Онц буудагч”, “Тамирчин дайчин” тэмдэгийг дараах шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч нарт олгоно. Үүнд:

2.2. “Онц сурлагатан” тэмдэгийг:

2.2.1. ЗХЖШ, командлалын цогцолбор болон сургуулийн жилийн төгсгөлийн шалгалтаар “Онц” дүнтэй шалгагдсан;

2.2.2. Хоёр хүртэл сургалтын шатанд “Онц” дүнтэй суралцсан;

2.2.3. Байлдааны болон хуулиар хүлээсэн тайван цагийн үүргийн тактикийн хээрийн сургуульд оролцож, албан тушаалын үүргээ “Онц” биелүүлсэн;

2.2.4. Цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаах хугацаандаа онцгой гавьяа байгуулсан;

2.2.5. “Онц буудагч”, “Тамирчин дайчин” тэмдэгтэнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан бол.

2.3. “Онц буудагч” тэмдэгийг:

2.3.1. ЗХЖШ, командлалын цогцолбор болон сургуулийн жилийн төгсгөлийн галын бэлтгэл хичээл болон буудлагын шалгалтад “Онц” дүнтэй шалгагдсан;

2.3.2. Хоёр хүртэл сургалтын шатны галын бэлтгэл хичээл болон буудлагын шалгалтад “Онц” дүнтэй суралцсан;

2.3.3. Тактикийн хээрийн сургуулийн байлдааны буудлага, харвалтыг “Онц” дүнтэй гүйцэтгэсэн;

2.3.4. Зэвсэгт хүчний болон төрлийн цэргийн командлалын аварга шалгаруулах цэрэгжлийн спортын тэмцээний буудлагын төрөлд оролцож, медальт байрт шалгарсан бол.

2.4. “Тамирчин дайчин” тэмдэгийг:

2.4.1. ЗХЖШ-ын цогцолбор болон командлалын шалгалт, сургуулийн жилийн төгсгөлийн шалгалтын биеийн тамирын бэлтгэл хичээлд “Онц” дүнтэй шалгагдсан;

2.4.2. Зэвсэгт хүчний болон төрлийн цэргийн командлалын аварга шалгаруулах цэрэгжлийн спортын уралдаан, тэмцээнд оролцож хувийн болон багийн дүнгээр медальт байрт шалгарсан;

2.4.3. Цэргийн алба хаах хугацаандаа улс, тив, дэлхий, олон улсын уралдаан, тэмцээнд оролцож хувийн болон багийн дүнгээр шагналт байрт шалгарсан.

2.5. Дайчилгаатай сургууль, цэргийн бэлтгэл сургалтад оролцох үедээ “Онц сурлагатан”, “Онц буудагч”, “Тамирчин дайчин” тэмдэгтэнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, онцгой гавьяа байгуулсан цэргийн бэлтгэл үүрэгтэнд зохих тэмдэгийг олгож болно.

Гурав. Тэмдгийг олгох албан тушаалтан, тэдгээрийн үүрэг

3.1. “Онц сурлагатан”, “Онц буудагч”, “Тамирчин дайчин” тэмдэг олгох эрхийг ЗХЖШ-ын удирдлага, төрлийн цэргийн командлагч, нэгтгэл, анги, байгууллагын захирагч, дарга нар, ЗХЖШ болон командлалаас томилогдсон цогцолбор шалгалтын комиссын дарга, сургуулийн удирдагч эдэлнэ.

3.2. “Онц сурлагатан”, “Онц буудагч”, “Тамирчин дайчин” тэмдэг олгох эрх бүхий албан тушаалтнууд нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

3.2.1. Энэхүү журамд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч нарт олгох;

3.2.2. Тэмдэг, үнэмлэх олгох үйл ажиллагааг үнэн зөв, шударгаар зохион байгуулах;

3.2.3. “Онц сурлагатан”, “Онц буудагч”, “Тамирчин дайчин” тэмдэгийг олгох үндэслэл, дүнгийн материал, тайланг ЗХЖШ-ын сургалт хариуцсан нэгжид хүргүүлэх;

3.3. Үнэмлэх дээр болзол хангасан цэргийн алба хаагчийн эцгийн болон өөрийн нэр, олгосон албан тушаалтны цол, овог, нэр, албан тушаал, олгосон огноог бичиж, гарын үсэг зурж, нэгтгэл, анги, байгууллагын тэмдэг дарж баталгаажуулан олгох.

ЗХЖШ-ЫН СУРГАЛТЫН ХЭЛТЭС